



ДУНДГОВЬ АЙМАГ
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 1474

Мандалговь

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14, 7 дугаар зүйлийн 7.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3, 16.3.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Хулд мандал ХХК-ны “Маргад”, Жинд болор ХХК-ны “Болор плаза” хүнсний дэлгүүрүүдэд тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2020 оны 04 дугаар сарын 06-ны өдрөөс 2022 оны 04 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл хугацаагаар олгосугай.

2.Утаат тамхи худалдан борлуулах үйл ажиллагаа эрхлэхдээ хууль, журамд заасан тавигдах шаардлагыг биелүүлж ажиллахыг “Хулд мандал” ХХК-ны захирал (З.Батзориг), “Жинд болор” ХХК-ны захирал (Г.Энхжаргал) -нарт үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн (Б.Саранзаяа), Цагдаагийн хэсгийн байцаагч (Б.Билгүүн), (А.Өлзийбуян) үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Р.МӨНХТОГТОХ

